



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн  
Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх салбар  
зөвлөлийн даргыг томилох тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалт, "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоол, "Ажилд томилох тухай" Засгийн газрын 2016 оны 105 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод яамны Төрийн нарийн бичгийн дарга Гунгаагийн Баясгаланг 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилсугай.

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Г.Баясгаланд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 12 дахь заалтын "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигмиддашийн Баярцэцэг," гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

